

UDC 930.85(517+510)+398

ДОМОГ ЗҮЙН ҮҮТГЭН БҮТЭЭГЧДИЙН (DEMIURGES) НЭРШИЛ, ЯЛГААНЫ ТУХАЙ АСУУДАЛД (МОНГОЛ-ХЯТАДЫН ДОМГИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

Молор-Эрдэнийн Сэцэнтунгалаг (Siqintonglaga)

МУБИС-ийн докторант, Улаанбаатар, Монгол Улс

Цахим хаяг: hsqtlg@gmail.com

Аюушжавын Алимаа, доктор (Ph.D)

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Аман зохиол судлалын салбарын ЭШТА,
Улаанбаатар, Монгол Улс

Цахим хаяг: alimaa_mgl@yahoo.com

Хураангуй

Өгүүлэлд домгийн үүтгэн бүтээгч, туурвигч болон соёлын баатруудын ялгаа зөрөөг домогзүйн онолын бүтээлүүдээс тодруулах гол зорилготой. Учир нь домог зүйн судалгааны бүтээлүүдэд хүний ертөнцийг бүтээгч, хүний үүсэл, соёлын анхдагчуудын талаар туурвигч баатар, бүтээгч эзэд, соёлын баатар, бурхад, сахиулсан, тотем өвөг, домгийн баатар, тэнгэр нэрүүд, трикстер, мөн туулийн баатар гэх зэрэг олон янз нэршил таарч байгаа бөгөөд янз бүрээр ойлгож, тэмдэглэж байна. Түүнчлэн домгийн гол баатрууд гэх, ертөнц дахиныг бүтээгчид: бурхан, сахиусан чөтгөр, амьтад гэх мэттэй холилдуулснаас ойлголтын ялгаа зөрөө багагүй байна. Эдгээр үүсгэн бүтээгчдийн цогцолбор Монгол олон Хятадын домогт өөр өөрийн онцлогтой ч, ерөнхий төлвөөрөө адил байгаа нь анхаарал татна. Ийнхүү жишээ, функцийн үүднээс тодруулахын тулд Монгол болон Хятадын домгийн сангаас туурвигч баатруудыг сонгон авч харьцуулан үзэж өөрсдийн дүгнэлтээ хийжээ.

Түлхүүр үг

Домог, домог зүй, Монгол домог, Хятад домог, туурвигч, үүтгэгч, бүтээгч баатар, соёлын баатар, харьцуулалт.

УДК 930.85(517+510)+398

К ВОПРОСУ О ЛИЧНОСТИ И РАЗЛИЧИЯХ МИФОЛОГИЧЕСКИХ ДЕМИУРГОВ (НА ПРИМЕРЕ МОНГОЛО-КИТАЙСКОЙ МИФОЛОГИИ)

Сэцэнтунгалаг Молор-Эрдэнэ

докторант, Монгольский государственный университет образования

Улан-Батор, Монголия

E-mail: hsqtlg@gmail.com

Алимаа Аюушджав

доктор (Ph.D)

Зав. сектором фольклора, Институт языка и литературы АН Монголии

Улан-Батор, Монголия

E-mail: alimaa_mgl@yahoo.com

А н н о т а ц и я

Основная цель данной статьи — разъяснить различия между мифологическими демиургами, творцами и культурными героями на основе теоретических работ по мифологии. Изучение сходств и различий в мифах соседних стран (Монголии и Китая) станет важным шагом в решении многих вопросов, таких как существование общих предков, взаимодействие разных культур, свободные версии устной истории и влияние условий миграции, общего климата или географической близости. К сожалению, на сегодняшний день практически не существует сравнительных исследований монгольско-китайских мифов и нет научных работ по этой теме. В мифологических исследованиях существует множество различных названий создателей вселенной и человеческого мира, предков человечества и первопроходцев культуры, таких как герои-создатели, творцы и создатели, культурные герои, боги, сахиусаны, хранители, тотемные предки, мифические герои, тенгрии, трикстеры и эпические герои, и они понимаются и прославляются по-разному. Кроме того, главные герои мифов, создатели мира (боги, тенгрии, сахиусаны, животные и т. д.) переплетаются между собой, и в их понимании существует значительная разница. Примечательно, что этот творческий комплекс в целом схож с монгольской и китайской мифологией, хотя и имеет различные особенности. При разъяснении примеров и сравнении функций создателей в монгольских и китайских мифах обычно обнаруживаются схожие сюжеты. Авторы разделили их на три категории: а) создатели, являющиеся «результатами» высокой абстракции, б) создатели тотемов, в) группы создателей.

Ключевые слова

Миф, мифология, монгольский миф, китайский миф, создатель, первопроходец, герой-создатель, культурный герой, сравнение.



О Р Ш И Л

Домог бол бидний өдөр тутмын амьдралын чухал бүрэлдэхүүн хэсэг гэсэн үзэл бодлыг таамаглал биш аксиом болгоход Ролан Барт, Курт Хюбнер зэрэг философичдын хувь нэмрээ орсон бөгөөд энэ нь социалист чиг баримжаатай улс орнууд домгийн тухай тодорхойлолтоо эргэн харахад хүргэсэн билээ. Тухайлбал, Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлсэн “Монгол утга зохиолын нэвтэрхий толь” (2022)-д *“Орчлон ертөнц, хүний нийгмийн юм үзэгдэл тэргүүтнийг танин мэдэж, тайлбарлах эртний эрмэлзлийг тусгаж, аяндаа урамсаргүй уран сэтгэмжээр зохиогдсон аман өгүүлэлт, хүүрнэлийн зохиолыг домог үлгэр гэнэ”* (Байгалсайхан, 2022: 340) гэжээ. Домог зүйч С. Соёлмаа “Домог (эрт. грек μῦθος хууч үг яриа) нь бурхад, баатруудын тухай ертөнцийн үүслийн тухай, ертөнцөд хүний эзлэх байр суурийн тухай төсөөллийг дамжуулах үг, яриа юм” (Соёлмаа, 2014: 12) гэсэн хоёр тодорхойлолтод хуучирсан болон өнөө цагийн ерөнхий тайлбарын аль аль нь байна.

Бусад улс оронд ч домгийг эртний бурхад, «шашин», «ид шид», «балар эртний үзэл ойлголтын тайлбар» гэх мэт ойлголтууд байсаар байдаг нь мифийг эртний домог гэх хүрээнд авч үзэж байгаа судалгааны зорилготой холбоотой болов уу. Хятадын домог зүйн гол төлөөлөгчийн нэг Лиү Күй Ли *“Домог бол балар эртний хүй нэгдлийн үед амьдарч байсан хүмүүс, баатрууд эртний сэтгэхүйгээрээ дамжуулан байгаль, ертөнц ба нийгмийн амьдралыг ухамсаргүйгээр дүрээр болон хүнчлэн бий болгосон хий хүслийн гайхамшигт урлагийн бүтээл мөн”* (Лиү Күй Ли, 2006) гэсэн бол «Хятадын соёл» (中国文化) чжунго вэньхуа) номын «Хятадын эртний домог» (中国古代神话 чжунго гудай шэньхуа) -д *“Домог бол эртний үеийн ер бусын буюу бурханчлагдсан баатруудын тухай түүхүүд юм. Домог нь хүн төрөлхтний эриний эхэн үед гарч ирдэг. Мааш эрт үеэс хүмүүс байгалийг ойлгож, өөрчлөхийг үнэхээр хүсч байсан хэдий ч тухайн үед бодит нөхцөл тааруу, танин мэдэхүйн чадвар сул байсан тул хүмүүс зөвхөн уран зөгнөл, байгаль, нийгмийн амьдралын ид шидийн дүрслэлд найдаж, энгийн овсгоотой тайлбар хийж, өөрсдийн гайхалтай хүсэл, итгэл найдвараа илэрхийлэхэд ашигладаг байв”* (中国文化 Чжунго вэньхуа, 1999: 10) гэхчлэн тайлбарлажээ.

Домог нь грекийн μῦθος буюу «үг» гэж орчуулагддаг бөгөөд олон улсад домог буюу миф хэмээн нэрлэж өргөн хүрээнд хэрэглэгдэх боллоо. Угтаа дээрх тодорхойлолтууд шиг академик ойлголтоор “эртний хүмүүсийн уран тайлбар” гэж үзэж байсан ч зарим философичдын (ялангуяа Р. Барт) тайлбарласнаар домгийн онолыг улс төр судлаач, маркетер, PR мэргэжилтнүүд ч анхааралдаа авах болсон юм. Үнэхээр хэл, сэтгэлгээ хөгжихийн хэрээр домог нь бодит байдлыг аман хэлбэрээр буюу үг, хэлээр тусгах цорын ганц хэлбэр байхаа больж, урлаг, шашин шүтлэгийн үндэс суурь болж хувирч байна.

Судлаачид домгийг үндсэнд нь эртний буюу архаик домог (анхдагч хүй элгэн, нийгмийн бүтээгдэхүүн), уран сайхнаар боловсрогдсон, илүү “нарийн” домог (олон нийтийн ухамсарт буй хэлбэр), орчин үеийн домог (шилжилтийн үеийн домог, рекламн домог...зэргээр чөлөөтэй хэрэглэх болсон) гэх мэтээр авч үзэх бололцоотой хэмээн тэмдэглэх болжээ (Дьяконов, 2004). Эртний домгуудыг авч үзэхэд дэлхийн

улс үндэстний домог өөр хоорондоо ижил төстэй байх, ижил өгүүлэмж, дүр, утга агуулгатай байх нь онцгой. Иймд үндэстнийхээ домгийн сэтгэлгээг ойлгохын тулд домог зүйн харьцуулсан судалгааг хүчтэй өрнүүлж байна.

Хөрш орнуудын домгийн ижил болон ялгаатай талыг судлан тогтоосноор тэдэнд нийтлэг өвөг дээдэс байсан уу, өөр өөр соёлуудын харилцан үйлчлэл үү, аман түүхийн чөлөөтэй хувилбарууд уу, эсвэл шилжин суурьшсан нөхцөлөөс шалтгаалсан уу, нийтлэг уур амьсгал, газар нутгийн ойролцоо байдлаас болов уу гэх олон асуудлыг шийдвэрлэхэд чухал алхам болно. Харамсалтай нь өдгөө хүртэл Монгол-Хятадын домгийг харьцуулсан судалгаа үндсэндээ хийгдээгүй, судалгааны бүтээл байхгүй байгаа юм.

Хоёр улсын харьцуулсан домгийн судалгааны тоймыг бүрдүүлж үзэхэд Бээжингийн Төвийн үндэстний Их сургуулийн профессор Г. Намжил үндсэндээ ганц төлөөлөл болж байна. Тэрээр домог зүйн судалгаагаар мэргэшсэн эрдэмтэн бөгөөд 2001 онд “Монгол домгийн харьцуулсан судлал” сэдвээр хэлбичгийн ухаанаар докторын зэрэг хамгаалжээ. 2001 онд Бээжинд “Монгол домгийн харьцуулсан судлал-монгол үлгэр домгийн харьцуулсан судлал” диссертация хэвлүүлсэн бөгөөд Ертөнцийн үүслийн домог, Хүний үүслийн тухай, Тэнгэр нэрийн домог, Нар, сарны домог, амьтан, ургамлын домгийг Хятадын 56 үндэстний домогтой харьцуулан үзсэн байна. Гэхдээ хятадын 56 үндэстэн гэдэг бол өргөн хүрээтэй асуудал бөгөөд түүний хэрээр эргэлзээ, маргаантай асуудал оршиж байна. Туурвигч баатруудын талаар харьцуулсан зүйл одоогоор байхгүй юм. Иймд бид, Монгол болон Хан үндэстний домгийн туурвигч баатруудын хүрээнд харьцуулах зорилт тавив.

ҮНДСЭН ХЭСЭГ

Нэг. Домогзүйн үүтгэгчдийн нэр нэршил, ялгааг тодруулах нь

Мифологийн үүсгэн бүтээгчид, соёлын баатрын тухай асуудал ертөнц бүтсэн тухай болон хүн төрөлхтний өвөг дээдэс хэн бэ, гэх асуудалтай холбогдоно гэсэн үг юм. Тухайлбал, домог зүйд хүний үүслийн тухай антропogоник домог нь орчлон ертөнцийг бүтээхэд зориулагдсан сав ертөнцийн (космогоник) домгийн нэг хэсэг юм. Энэ төрлийн домгийн бүтцийн хэд хэдэн талыг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Үүнд,

А) Хүнийг бүтээсэн демиургууд (эсвэл соёлын баатрууд).

Б) Хүнийг бий болгосон юмс (бодис).

В) Ээлж дараалалтай бүтээгдэх нөхцөл.

Г) Тэнгэр газрын холилдол дундаас хүн төрөх.

Д) Анхны хүний домог.

Е) Тэнгэр, Газар дорх ертөнц, өөр харь газраас ирсэн гэх мэтээр багцалж болно.

Монгол домогзүйн бүтээлүүдэд хүний ертөнцийг бүтээгч, хүний үүсэл, соёлын анхдагчуудын талаар туурвигч баатар, бүтээгч эзэд, соёлын баатар, бурхад, сахиулсан, тотем өвөг, домгийн баатар, тэнгэр нэрүүд, трикстер, мөн туулийн баатар гэх зэрэг нэлээд олон нэр томьёо, нэршил таарч байна. Эдгээрээс гол ойлголтуудыг ялган зааглах, нэр томьёоны утгыг тодорхойлох нь судалгааны өргөн боломжийг олгоно.

Бидний бодлоор «үүтгэгчид», “үүтгэн бүтээгчид”, “үүтгэгч эзэд” гэдэг бол эртний домгийн хамгийн ерөнхий шинжтэй байдаг. Үүнийг бүдүүвчээр авч үзвэл,



Зураг 1. Үүтгэгч буюу ертөнц, хүнийг үүсгэн бүтээгчид

Домог зүйн онолд **туурви́гч** буюу демиургуудыг нэн тэргүүнд дурддаг. Демиургуудыг бурхадын нэр гэж үздэг ч домог зүй, шашин судлалд өргөн хэрэглэгдэнэ. Эртний Грекийн домог зүйд ч, Монгол болон Хятадын домогт ч ертөнцийг эмх замбараагүй (хаос) байдлаас үүдэн бүтээсэн ертөнцийг “цэгцлэгч” дэлхий ертөнц болон түүний доторх бүх зүйлийг бүтээгчид (бурхад) гэж өгүүлнэ (<http://dictionary.cambridge.org>). Олонхи домог зүйд демиург нь сансар ертөнцийг зөвхөн бүтээн байгуулсан бус харин “тохиромжтой” аргаар, жишээлбэл, ид шид, дом шидээр, эсвэл зүгээр л үг хэлээд бүтээчихдэг бүтээгч бурхан (хят. сахиулсан)-ы хийсвэр дүр төрхтэй нийцтэй. Гэсэн ч философд бүтээгч эзэд гэсэн нэр томъёо нь илүү өргөн утгатай болсоор байна.

Соёлын баатар бол (англ. Culture hero) нь янз бүрийн соёлын эд зүйлсийг (гал, таримал ургамал, багаж хэрэгсэл) олж авах, авчрах, эсвэл хүмүүст зориулан анхлан бүтээдэгчид, хүн төрөлхтөнд ан гөрөө, гар урлал, урлагийн, зүйл тэргүүтнийг зааж, нийгмийн тодорхой зохион байгуулалт, гэрлэлтийн дүрэм, ид шидийн ёстой танилцуулсан домогт дүр юм (Мелетинский, 1982, 2: 25-26) Соёлын баатрууд демиургуудын адил дэлхийг бүтээхэд оролцож байсан гэх өгүүлэмжүүд бий. Тухайлбал, далайн ёроолоос газар авах, тэнгэрийн эрхисийг бий болгох, өдөр, шөнө, улирал, далайн түрлэгийг зохицуулах, анхны хүмүүсийг бүтээх, төлөвшүүлэх, хүмүүжүүлэхэд оролцох гэх мэт (A500-A599, A1703, A1058, A2252.3, A978.1). Хятадын домог зүйн сахиулснууд бол олонхидоо соёлын баатар болно.

Тэнгэр нэр (тэнгэрүүд) (Пантеон) бол ямар нэг шашин, домог зүйд харьяалагддаг, тодорхой чадвар, эрх мэдэл, үүрэг бүхий бүлэг бурхад. Тэд тус бүрдээ дэлхий, хүний амьдралын үе шат, үйл явдлыг удирдаж, нөлөөлдөг гэж үзнэ.

Домог нь нэн эртний учир үүргийн хувьд туурви́гч болон соёлын баатрууд холилдох тал олонтоо тохиолдоно. Дэлхий эхлэлтэй бол төгсгөлтэй. Дэлхийн төгсгөлд **баатар-аврагчид** байхыг домогт өгүүлнэ. Тэднийг мөн “демиургуудын” ойролцоо соёлын баатрууд гэж үздэг боловч тэдний үүрэг нь өөр агуулгатай. Тэд хуучин мууг устгаж, эерэг, үнэт зүйлсээр дүүрэн шинэ, эв найрамдалтай ертөнцийг бий болгохын тулд сайн ба муугийн хүчний хоорондох эцсийн тулаанд сайн сайхныг дэмжигч үүрэг гүйцэтгэдэг.

Мөн домог зүйд туурви́гч болон соёлын баатруудын эсрэг, өрсөлдөгч баатрууд (анти) гэж бий. Тэд домогт хосломол чанарыг бүрдүүлэх ба домгийн баатрын эерэг, сөрөг талыг гүн гүнзгий, тодоор харуулах боломжийг олгоно.

Хоёр. Монгол -Хятадын домог дахь туурви́гч эзэдийн зарим харьцуулалт

Туурви́гчдыг өөр зуур нь нарийн зааглан салгах боломжгүй байдаг ч хэв шинжийн хувьд,

– **Өндөр хийсвэрлэлийн “үр дүн” болсон туурви́гчид.** Туурви́гчид нь хүний бодит төсөөлөөс илүү тийм эрхэмсэг дээд тэнгэр, бурхад байх бөгөөд тэдний бодох, хэлэх зуур алив бүхэн биелэж бүтэх тул тэд дэлхий ертөнцийг бүтээгчид юм.

Хүснэгт 1

Монгол, Хятадын домгийн туурви́гчид

агуулга	Монгол домгийн туурви́гчийн төлөөлөл Тэнгэр-Бурхан багш (уг нь Хан Хормуст), Очирваань, Манзушир, Цагаан шүхэрт, Чингис хаан, Шуламас	Хятад домгийн туурви́гчийн төлөөлөл Пан Гү
Бүтээгч үйл	– Ертөнцийг бүтээсэн, – Эрхис: нар сар, од мичдийг хийсэн, – Хүнийг бүтээсэн, – Амьтдыг бүтээсэн	– Ертөнцийг бүтээсэн, – Эрхис: нар сар, од мичдийг хийсэн, – Арга, билгийн хүчний эх үүсвэр,

Монгол домгийн ертөнц дэлхий бүтсэн тухай туурви́гчдын зарим домгуудыг авч үзвэл, “Хүний үүслийн тухай” [Бурхан бүтээсэн] (Беннигсен, 1912: 6–7, 14–15), “Ертөнц бүтсэн тухай” [Хормуст хаан, Бурхан багш-Шагжтүв бүтээсэн] (Беннигсен, 1912: 12–13), “Газар дэлхийг бий болгосон нь” [Бурхан-Шагжтүв бүтээсэн] (Беннигсен, 1912: 13–14) гэхчлэн Бурхан, Бурхан багш бүтээсэн тухай өгүүлсэн нь хожуу үеийн Бурханы шашны нөлөө юм. Тухайлбал, “Ертөнц бүтсэн тухай” домогт “Манай газар дэлхийд эмх замбараагүй галав (хаос) ноёрхож байжээ. Тэгээд хүчтэй салхи гарч өтгөрч. Тэгтэл гал гарч өтгөрсөн салхийг хатааж, эцэст нь бороо орж, бүхнийг норгон дэвтээж энэ бүхний дүнд газар бий болжээ. Тэгэхдээ бүрэн бүтээгүй байв. Бурхан багш Хормутс хаанд очиж газар дэлхийг бүтээж өгөөч гэж гуйжээ. Хан тэнгэрүүд тэр цагт маш хүчтэй, хүссэн бүхэн тэр даруй санасанчлан бүтдэг байжээ. Тэгээд тэр газрыг бүтээжээ...” (Беннигсен, 1912: 12) гэснээс Хан Хормуст газар дэлхийг анхлан бүтээсэн туурви́гч гэдгийг өгүүлсэн бөгөөд харамсалтай нь ийм домог цөөн юм. Монгол домог зүйн анхны туурви́гч бол **Хурмаст тэнгэр** (Хан хурмаст бөгөөд хожим Бурхан багш (Шагжамуни, Очирваань г.м.)-д шилжсэн нь гарцаагүй. Зарим судлаачийн (Б.С. Дугаров) үзэхээр Хан Хормуст тэнгэр бол хожуу үед орж ирсэн гэж баталсан байдаг (Дугаров, 2005). Нөгөө талаар энэ мэт домгуудыг монголчууд амаас ам дамжуулан ярьж ирсэн бөгөөд зарим хэсэг нь оросын жуулчин, аялагч нарын бүтээлд тэмдэглэгдэн үлдсэн билээ.

Харин хятадын домгийн гол туурви́гч бол Пан Гү юм. Пун Гү 18000 жилийн турш өндгөнд байж байгаад түүнээс гарч Тэнгэр, Газрыг салгасан буюу өндөгний хөнгөн, тунгалаг (ян) бүхэн дээш дэгдэж Тэнгэр, хүнд, булингар бүхэн (ин) доош урсан Газар болжээ. 18000 жил өсөж, өөрөө бурхан болжээ. Нэгэн хувилбар домогт өгүүлснээр түүнийг үхсэний дараа түүний амьсгал салхи, үүл, үс нь аянга, цахилгаан, зүүн нүд нь нар, баруун нүд нь сар болж, гар хөл мөчдөөс уулс, дөрвөн зүг болж, цус нь гол ус, биеийн шар үснээс өвс ногоо, шүд, яс нь элдэв чулуу, төмөрлөг, хөлс

нь бороо, шүүдэр, тархи нь сувд, хаш тэргүүтэн бүтжээ. Харин түүний биед байсан шимэгч хорхойноос хүн бий болсон гэдэг. Өөр хувилбарт түүнийг нүдээ анивал шөнө, нээвэл өдөр болдог болж гэх мэтээр өгүүлдэг. Ийнхүү бүтээгч эзний жинхэнэ домгийн ёсоор бүхнийг бүтээж, өгч, үхсэний дараа ч бүтээх үйл өрнөж байна. Гэхдээ хятадын домогт үүтгэн бүтээгч нэг л эзэн байдаг гэж үзэж болохгүй бөгөөд монгол домгийн нэгэн адил олон тооны бүтээгч бурхад (сахиулсан) гарна. Тухайлбал, Пан Гү-гээс гадна Нью Ва гэх эмэгтэй туурвигч томоохно байртай. Тэрээр хүнийг шавраар бүтээсэн гэж өгүүлдэг нь монгол домогт эр, эм хүнийг шавраар бүтээсэнтэй адил санаа юм. Мөн зарим хувилбарт Нью Ва Тэнгэрийг бүтээгээд олон өнгөт чулуугаар бат бэх болгосон бол Газрыг аварга яст мэлхийний хөлөөр бэхжүүлсэн гэнэ. Энэ нь монголчуудын хуурай дэлхий их далайд эехийгөө дээш харуулсан сэлж байгаа яст мэлхийнийн дээр тогтож байгаа гэх өгүүлэмжтэй төслөг (Дулам, 1998: 184–185).

– **Туурвигч-тотем амьтад.** Монгол домогт үүсгэгч буюу туурвигч тотем амьтдын дүр олон бий. Тухайлбал, “Анх манай дэлхий одоох шиг хөрс шороо гэж байхгүй усан бүрхмэл байсан гэдэг. Тэгээд хурмаст тэнгэр, галбинга гэдэг шувууг маний энэ дэлхий уруу явуулжээ. Тэр шувуу гурван түмэн жилийн настай юм байна. Нэг түмэн жил бодлоод нэг өндөг гаргадаг гэнэ. Тэгээд өндөг засах газар олдохгүй усан бүрхэм-эл дээгүүр нисч, эцэс сүүлд өдөө зулгааж усан дээр үүр засаад өндгөлжээ. Тэр зассан үүрийн дээр нь хумхийн тоос суусаар байгаад газрын хөрс үүссэн байна. Гуравдахь түмэн жилд гарсан өндөгнөөс нь янз бүрийн амьтан үүсч сүүлд нь хүн болжээ. Ингэж хөрст дэлхий тогтсон юм гэнэ (Цэрэнсоном, 1989: 38). Энд хятадын Пан Гү буюу ертөнц анх өндөгнөөс үүссэн гэдэг өгүүлэмжийн сэжим байх мэт. Ерөөс Европын домогт ертөнцийн үүсэл өндөг хэмээн домоглоно.

Хятадын домгийн гол амьтан луу бол хэдийгээр тотем боловч туурвигч биш юм. Тэрээр газрын ин хүчээ алдаж тэнгэрийн ян буюу арга талын төлөөлөл болсон байгалийн сүр хүчний төлөөлөл домгийн амьтан.

– **Туурвигч бүлэг.** Олуул буюу эсвэл ихэр туурвигч бурхадын тухай домогзүйн онолын бүтээлүүдэд онцлон үзсэн байдаг. Бидний хувьд, монгол домогт төдийлөн байхгүй, хожмын буюу шашны нөлөө бүхий домогт буддын бурхад бүлэг үүсгэсэн шинж төлөв ажиглагдана гэж үзэж байна. Монгол домог, тууль, үлгэрийн хүрээнд авч үзэхэд Хан Хурмаст байж болохоор баримтууд олон байдаг. Гэвч буриадын эрдэмтэн Б.С. Дугаров Гэсэрийн туужийн судалгаандаа Хөхдэй Мэргэнийг онцолж үзсэн бөгөөд “Монгол, Түргийн аман зохиол, домгийн уламжлалд Төв Азийн Тэнгэрийн тухай үзэл санааны хамгийн дээд ариун нандин зарчмын гол түүхийг тээгч” гэж үзэж эцэг-тэнгэр, хүү-тэнгэрлэг баатар гэсэн хоёрдмол шинж чанартай гэж тодорхойлсон” төдийгүй дээд гурван эцэг бурхан бол Эсэг Милаан тэнгэр, Заян Сагаан тэнгэр, Хөхдэй Мэргэн тэнгэр гэж үзсэн нь бурханы шашин домог зүйд “байрших”-аас өмнөх монголчуудын домгийн эртний ойлголтын нэг үе шат байж болно (Дугаров, 2005: 35–38).

Харин хятадын домогт бүлэг байдалтай сахиулсан (бурхад) гэж байна. Гэхдээ демиургийн үүргийг орлосон, гүйцэтгэсэн байдал төдийлөн байдаггүй.

Домгийн туурвигчдыг нарийсгавал туурвигч-баатар гэсэн хэв шинж байж болох ч энэ талаар гүнзгий судалгаа шаардагдана. Тухайлбал, Чингис хаан зэрэг домгийн баатрууд нь дэлхий дээрх бүх зүйлийг бүтээгчээр яригддаг бөгөөд Гэсэр ч, Чингис хаан ч тэнгэрээс бууж ирсэн гэдэг агуулга олон. Тэд газар шороо, уулс, гол

мөрөн, суваг, зам, мод, ургамал, амьтан, анхны хүмүүсийг бүтээж, тэдэнд янз бүрийн чадварыг өгч, эд зүйлсийг бүтээдэг. Жишээ нь, Чингис хаан етөнцийг бүтээсэн бөгөөд арван чуу (шуу) унасан Чуу мэргэн юм (Потанин, 1883, 4: 232). Мөн Гэсэр шулмасын чихэнд үерийн дараа үлдсэн тоосны тоосонцороос дэлхийг бүтээсэн бол Очирваань газар дэлхийг Цагаан шүхэрт, шуламын хамсраатай өөрийн шидийг ашиглан бий болгож байна. Энэ талаар домогт “Ертөнц анхандаа усгүй байжээ. Газар ч бий болоогүй байж. Очирваань тэнгэрт амьдрах тул амарч суух газаргүй тул амрах газар хайжээ”. Тэгээд Цагаан шүхэрттэй тааралдаж түүгээр их усанд хөвөх мэлхий дээр шороо шавар асгуулан газар бүтээж сууна. Гэвч хэмжээ нь бага байж. Энэ зуур шулмас ирж тэр газарт багтах зай байхгүй тул тэднийг түлхэж унагахаар газрын захаас барьж автал газар уртсаад, томсоод ирж. Дээр нь гарч ирээд нөгөө хоёр руу гүйтэл гүйх тусам газар нь томорсоор байжээ. Очиваань, Цагаан шүхэртээ сэрээж газар биднийг Шулмаас аварлаа гээд газар дээгүүр алхаж явахдаа Очирваань “Чи миний туслах. Тиймээс одоо энэ газар дээр амьд зүйлийг бүтээе” (Потанин, 1883, 4: 221–224) гэжээ. Энэ мэтээр олон баатар, домгийн болон тууль болон бодит дүрүүдтэй холбогдож байна.

ДҮГНЭЛТ

Домгийн сэтгэлгээ бол ерөнцийг үзэх үзэл, орчлон ертөнцийг болон болон юмс үзэгдлийн эх үүсвэр, бүтэц тогтоцыг тайлбарлахад оршдог. Эртний домогзүйн сэтгэлгээ нь зүй ёсоор хүн төрөлхний анхдагч, танин мэдэхүйн илэрхийлэл, аливаа юмс үзэгдлийг уран санаагаар хийсвэрлэн дүгнэх тогтолцоо мөн билээ. Харин орчин цагт нийтийн ухамсарыг удирдах, төрийн үзэл суртлыг төлөвшүүлэх, нийгмийн дэг журмыг сахиулах тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг болж байна. Иймд домгийн тодорхойлолт илүү өргөн, нарийн болж байгааг анхааралдаа авах ёстой. Мөн нэр нэршлийн асуудал домог зүйн судалгаанд чухал байна. Бид сав шим ертөнцийн домгийн хүрээнд үүсгэн бүтээгчдийн нэршлийн тус бүр тайлбарлахыг хичээсэн бөгөөд ерөнхийд нь үүтгэгчид гэж нэрлээд дотор нь туурвигч баатар, соёлын баатар гэх зэргээр түвшин, гүйцэтгэх үүрэг зэргээр ялган холбогдох баатар, тэнгэр нэрүүдийг багтаах нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүллээ.

Монгол-Хятад домгийн судалгаа домогзүйн онол, арга зүйн хүрээнд хийгдсээр ирсэн бөгөөд аль алианаас нь домгийн ангилал сонгодог домогзүйн ойлголтын үүднээс туурвигч эздийг харьцуулан авч үзэхэд ерөнхийдөө ижил төстэй өгүүлэмжтэй байгааг а) Өндөр хийсвэрлэлийн “үр дүн” болсон туурвигчид, б) Тотем-туурвигчид, в) Туурвигч бүлэг хэмээн ангилж тус бүрд жишээгээр харьцуулсан бөгөөд цааш туурвигч-баатрууд, туурвигчдын эсрэг үүтгэгчид буюу антипотуудын талаар үргэлжлүүлэн авч үзэх боломжтой байна. Өөрөөр хэлбэл, туурвигч баатруудын систем тогтолцоог харьцуулсан судалгааны үндсэнд бий болгох нь зөв шийдэл ажээ. Мөн үүтгэгч, үүсгэгч демиургуудын шалгуур үзүүлэлтийг бурханы шашин, цаг хугацаа, гүйцэтгэх үүрэг, домгийн шинж чанар, дүр-баатар зэрэг домогзүйн онолын хүрээнд харьцуулсан судалгаагаар тогтоох нь онол-аргазүйн зөв чиг баримжаа гэж үзэж байна. Монгол-хятадын домгийн харьцуулсан судалгаа эхлэл төдий байгаа энэ үед дэлхийн домогзүйн чиг баримжаагаар эхнээсээ зөв системтэй судлах шаардлагатай.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Беннигсен, А.П. (1912). *Легенды и сказки Центральной Азии*. СПб.
- Гаадамба, Ш., Сампилдэндэв, Х., Цэрэнсодном, Д. (1991). *Монгол ардын аман зохиол*. Монгол бичгээр. ӨМ-ын багачууд хүүхдийн хэвлэлийн хороо.
- Дугаров, Б.С. (2005). *Сакральный мир бурятскрй Гэсэриады: Небесный пантеон и генезис героя*. Улан-Удэ: Издательство БНЦ СО РАН.
- Дулам, С. (1998). *Монгол домогзүйн дүр*. Хайлаар.
- Дьяконов, И.М. (2004). *Архаические мифы Востока и Запада*. М.: Едиториал УРСС.
- Лиу Шү Хуа (2006). *Үлгэр зүйн ухаан*. Хуа зүн-Багшийн их сургуулийн хэвлэлийн хороо.
- Лиу Куй Ли (1982). *Домог хийгээд домгийн ухаан. Аман зохиолын тавцан*.
- Мандах (2003). *Ардын аман зохиолын онол*. Леонины үндэстний хэвлэлийн хороо. Мелетинский, Е.М. и др. (1982). *Мифы народов мира*. Энциклопедия. 2. М.: Сов. энцикл.
- Монгол утга зохиолын нэвтэрхий толь* (2022). 1. Ерөнхий редактор С.Байгалсайхан. УБ.
- Потанин, Г.Н. (1883). *Баруун-хойт Монголын тэмдэглэл*, 4.
- Цэрэнсодном, Д. (2013). *Монгол ардын домог үлгэр*. Улаанбаатар: Номун гэрэл төв. Хоёрдахь удаагийн хэвлэл.
- Ян Ли Куй, Жан Чун Фу (2018). *Хятадын домгийн хэлхээс*. Шаншигийн Багшийн Их сургуулийн хэвлэлийн ерөнхий хороо.
- Янжинсүрэн, С. (2006). *Хятадын шашин шүтлэг хийгээд Күнзийн суртал. МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургууль. Философи, шашин судлал*. 4. 253 (30).

References

- Bennigsen, A.P. (1912). *Legends and Fairy Tales of Central Asia*. St. Petersburg (in Russian).
- Gaadamba, Sh., Sampildendev, Kh., Tserensodnom, D. (1991). *Mongolian Folklore*. Mongolian script. Children's Publishing House of the Ministry of Education (in Mongolian).
- Dugarov, B.S. (2005). *Sacred World of the Buryat Geseriady: Heavenly Pantheon and the Genesis of the Hero*. Ulan-Ude: Publishing House of the BNC of the Siberian Branch of the Russian Academy of Sciences (in Russian).
- Dulam, S. (1998). *Mongolian Mythological Characters*. Khailaar (in Mongolian).
- Dyakonov, I.M. (2004). *Archaic Myths of the East and the West*. Moscow: Editorial URSS (in Russian).
- Liu Shu Hua (2006). *The Science of Fairy Tales*. Huazun-Bagshin University Publishing House (in Mongolian).
- Liu Kui Li (1982). *Mythology and Mythology*. Oral Literature Platform (in Mongolian).
- Mandakh (2003). *Theory of Folklore*. Leonine National Publishing Committee (in Mongolian).
- Meletinsky, E.M., etc. (1982). *Myths of the Peoples of the World*. Encyclopedia. 2. Moscow: Sovetskaya entsiklopediya (in Russian).
- Encyclopedia of Mongolian Literature* (2022). 1. Editor-in-chief S.Baigalsaikhan. UB (in Mongolian).
- Potaniin, G.N. (1883). *Ocherki Severo-Zapadnoy Mongolii* [Essays of Western-Northern Mongolia]. 4. SPb. (in Mongolian).
- Tsersodnom, D. (2013). *Mongolian Folk Myths and Tales*. Ulaanbaatar: Nomun Light Center. Second edition (in Mongolian).

Yang Li Kui, Zhang Chun Fu (2018). *Chinese Mythology*. General Publishing Committee of Shanxi Normal University (in Mongolian).

Yanzhinsuren, S. (2006). Chinese Religion and Confucianism. *School of Social Sciences, National University of Mongolia. Philosophy and Religious Studies*. 4. 253 (30) (in Mongolian).